



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
АЛБАН ДААЛГАВАР

2022 оны 01 сарын 24 өдөр

Дугаар 01

Чингис хот

Хүүхдийн эрхийг хамгаалах,
эрсдэлээс урьдчилан сэргийлэх тухай

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 11 дугаар зүйлийн 17.1.2, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хангах тухай 01 дүгээр албан даалгавар, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 201 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ДААЛГАХ нь:

1. Хүүхдийн эрхийг хамгаалах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр доор дурдсан үйл ажиллагааг зохион байгуулж тайлан мэдээллийг хагас бүтэн жилээр гарган Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газарт ирүүлэхийг сумдын Засаг дарга, агентлаг, байгууллагын дарга нарт, ирүүлсэн тайлан мэдээг нэгтгэн, дүгнэж аймгийн Засаг даргын тамгын газрын Хяналт-шинжилгээ үнэлгээний хэлтэст тухай бүр ирүүлж байхыг Гэр, бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газарт тус тус даалгасугай.

Сумдын Засаг дарга буюу Хамтарсан багийн ахлагч нарт:

1. Хүүхдийн төлөө зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлж, тогтмол хуралдуулан шаардлагатай асуудлуудыг цаг алдалгүй шийдвэрлэж байх

2. Сумын хүүхдийн аж байдлын талаарх судалгааны санг бүрдүүлэн, сумын хүүхэд хамгааллын нөхцөл байдлыг тодорхойлж, хүүхдэд ээлтэй орон нутгийн бодлоготой болсон байх

3. Орон нутагтаа хүүхдийн саналыг сонсох үйл ажиллагааг тогтмолжуулан, хүүхдээс гарсан санал санаачлагыг дэмжин, бодлого шийдвэртээ тусгаж ажиллах

4. Хамтарсан багийн үйл ажиллагааг идэвхжүүлж, урьдчилан сэргийлэх болон хариу үйлчилгээний чанар, хүртээмж, шуурхай байдлыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулж, эрх нь зөрчигдсөн хүүхдэд хамгааллын үйлчилгээг түргэн шуурхай хүргэх

5. Хариуцсан нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд "Өвөл хаврын улиралд хурдан морины уралдаан, үсэргээ сунгааг" хориглох зохион байгуулсан тохиолдолд шуурхай арга хэмжээ авах эрх бүхий байгууллага албан тушаалтанд мэдэгдэх

6. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх хөршийн холбоог сайжруулах, хүчирхийлэлд өртсөн хохирогчдыг холбогдох байгууллагуудад мэдэгдэж, хамтран ажиллах хандлага төлөвшүүлж, хууль эрх зүйн мэдлэг мэдээллээр хангах

7. Бага насны хүүхдийг хараа хяналтгүй орхих, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж хүүхдийг болзошгүй эрсдэл, ахуйн осол, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, эцэг эх асран хамгаалагчдын үүрэг, хариуцлага, хүүхдэдээ тавих анхаарал, халамжийг нэмэгдүүлэх чиглэлээр зөвлөмж чиглэлийг байгууллагын дэргэдэх эцэг эхийн зөвлөлөөр дамжуулан хүргэх

8. Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төвөөс шилжүүлсэн хүүхэд хамгааллын дуудлага, мэдээлэл дээр шуурхай ажиллаж, хүүхэд хамгааллын хариу

231020001

2.

үйлчилгээг Хамтарсан багаар хүргэж, кейс шийдвэрлэлтийг сайжруулахад анхаарч ажиллах

9. Эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа, хүчирхийлэлд өртөх эрсдэлтэй хүүхэд, гэр бүлийн (хойд эцэг эхтэй, архины хамааралтай, түр оршин суугч, дахин гэрлэсэн, ял эдэлж байсан хүнтэй гэр бүл болсон, тавиул, хараа хяналт сул) бүртгэл судалгааг шинэчилж, кейс нээн, хариу үйлчилгээг үзүүлж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх (хүүхдийн даатгалд хамруулах ажлыг зохион байгуулж ажиллах)

10. Сумын нийт байгууллагуудын 80-аас доошгүй хувийг хүүхэд хамгааллын бодлоготой, эцэг эхийн зөвлөлтэй болгох ажлыг зохион байгуулах, эцэг эхийн зөвлөлөөр дамжуулан ажилтнуудын сайн эцэг эх байх боломжийг хангах нөлөөллийн ажлыг зохион байгуулах

11. Харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын ажилтан, албан хаагчдын ажил, амралтын горимыг хууль журамд заасны дагуу мөрдүүлж ажиллах, эцэг эхчүүдийг хүүхэд, гэр бүлдээ цаг гаргаж, гэрээр ажиллах боломж нөхцлөөр хангах

12. Орон нутагт хүүхдэд учрах эрсдэлийн орчны үнэлгээ хийж, хүүхдийн амьдрах, суралцах, хөгжих аюулгүй орчныг бүрдүүлэх ажлыг төлөвлөлт, шат дараалалтай хийх (гудамж талбайн гэрэлтүүлэг, халтиргаа, замын хөдөлгөөний аюулгүй байдал, гудамжны тэмдэг тэмдэглэгээ, золбин нохой, эзэнгүй барилга, нүх шуудуу гэх мэт)

13. Сургууль, цэцэрлэг нийтийн эзэмшлийн биеийн тамирын болон хүүхдийн тоглоомын талбайн орчны гэрэлтүүлгийг сайжруулж, гадна, дотор орчны камерын хяналтын системээр бүрэн хангах, эрсдэлтэй тоног төхөөрөмж, тоглоомын хэрэгсэлд засвар үйлчилгээ хийх ажлыг зохион байгуулах

14. Дотуур байр болон хичээлийн байрны АЦБ-ийн стандартыг хангах, 6-12 настай хүүхдийг өвлийн цагаар гадна 00-д бие засуулахгүй байх

15. Боловсролын байгууллагын ажилчидтай хамтран гэр айлчлалыг хамтран зохион байгуулах, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, багш нарыг урамшуулах

16. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрх ашгийг хамгаалж, нийгмийн үйлчилгээ авах боломжоор ханган, гадна налуу шатыг стандартын дагуу болгож, орон нутагтаа дохионы хэлний хэлмэрч багш бэлтгэх арга хэмжээ авах

17. Болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор ЕБС-ийн бага ангиас эхлэн анги бүлгийг камержуулах ажлыг өрнүүлэх

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт:

1. Сумын хамтарсан баг, хүүхдийн төлөө зөвлөл, хүүхдийн асуудлаар үүрэг хүлээгчдийг чадавхжуулах, ажлын явцыг тогтмол үнэлэн, арга зүй, зөвлөмж, чиглэлээр хангах

2. Аймгийн хэмжээнд хүүхэд хамгааллын нөхцөл байдлын мэдээллийг нэгтгэн, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн судалгааг нэгдсэн нэг аргачлалаар тооцох арга зүйг боловсруулан ашиглах

3. Эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа хүүхдийн нөхцөл байдал, хэрэгцээг тодорхойлох түргэвчилсэн үнэлгээ хийж, тэн шаардлагатай тусламж дэмжлэгийг шуурхай үзүүлэх, шаардлагатай санхүүгийн тооцоог гаргаж, аймгийн ХТЗ-д тавьж шийдвэрлүүлэх

3.

4. Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төвөөс шилжүүлсэн хүүхэд хамгааллын дуудлага, мэдээлэл дээр шуурхай ажиллаж хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг үзүүлж кейс шийдвэрлэлтийг сайжруулахад анхаарч ажиллах

5. Цахим, зайны сургалт зэрэг арга хэлбэрүүдийг ашиглан цагийг үр дүнтэй, бүтээлч өнгөрүүлэхийг уриалах, арга зүйгээр хангах, хүүхдийн хөгжлийн хөтөлбөрийг бэлтгэн хүргэх

6. Хүүхэд хамгааллын салбар дундын хамтын ажиллагааг идэвхжүүлж тус албан даалгаврын хэрэгжилтийг удирдлага зохион байгуулалт, арга зүйгээр хангаж ажиллах

Аймгийн Онцгой байдлын газарт:

1. Монгол Улсын Засгийн газрын 201 дүгээр тогтоолоор батлагдсан “Онцгой нөхцөл байдлын үед хүүхдийн эрхийг хамгаалах, тусламж дэмжлэг үзүүлэх журам”-ын дагуу мэргэжлийн ангийг удирдлага, арга зүйгээр хангаж ажиллах

2. Хүүхдийг гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх тэр дундаа бага насны хүүхдийг болзошгүй эрсдэл (ахуйн осол, гал түймрийн аюул)-аас сэргийлэх чиглэлээр заавар зөвлөмжийг иргэд, олон нийтэд таниулах ажлыг зохион байгуулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх үзлэг шалгалтыг тогтмол хийх

Боловсролын газарт:

1. Сургууль, цэцэрлэгийн хүүхэд хамгааллын баг, анги удирдсан багш нараар дамжуулан гэр бүл, хүүхдийн эсрэг хүчирхийллийн далд хэлбэрийг илрүүлэх, таслан зогсоох арга хэмжээг өргөн хүрээнд зохион байгуулж, тогтмол хяналт тавьж холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах

2. “Хүүхэд хүмүүжлийн эерэг арга” арга зүйг түгээн дэлгэрүүлэх хүрээнд ерөнхий боловсролын сургуулийн багш, сурагчдад чиглэсэн эерэг хандлага, харилцааны сургалтыг тогтмол, үр дүнтэй зохион байгуулах

3. Сэтгэл зүйн гутрал, хямралд орсон хүүхдийг анхан шатны сэтгэлзүйн үйлчилгээнд хамруулах

4. Өсвөр насныханд зориулсан “Эх хүн болно. Эргээд хүүхэд болохгүй” аяныг жил бүр өрнүүлж, нөхөн үржихүйн эрүүл мэндийн сургалт, нөлөөллийн олон талт арга хэмжээг хүүхэд, анги удирдсан багш, эцэг эхчүүдэд тохиромжтой хэлбэрээр тогтмол зохион байгуулах

5. Хүүхдийн клуб, оролцооны байгууллагаар дамжуулан, өсвөр насныхны санал сэтгэгдэл, тулгамдсан асуудлыг сонсох, дотно ярианы цагтай болох

6. Сар бүр бүтэн болон хагас өнчин, зорилтот бүлгийн хүүхдүүдтэй уулзах өдөртэй болж, тэдний өмнө тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх, холбогдох байгууллага, иргэдтэй хамтарч ажиллах

7. Цаг үеийн нөхцөл байдлыг харгалзан улирал бүр бүтэн болон хагас өнчин, зорилтот бүлгийн хүүхдүүдийн гэрээр айлчлах, гэр бүлийн орчинтой танилцах, эцэг эх, асран хамгаалагч нартай уулзалт зохион байгуулж, тодорхой асуудлыг шийдвэрлэх, шаардлагатай бол сэтгэл зүйчтэй хамтарч ажиллах

8. Сургуулийн орчинд 19 цагаас хойш хүүхэд цуглуулах арга хэмжээ зохион байгуулахгүй байх

Аймгийн Цагдаагийн газарт:

1. Хөршийн холбоог идэвхжүүлэх, хараа хяналтгүй хүүхэд, хүчирхийлэл, гэмт хэрэг, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхэд, эцэг эх, асран хамгаалагчаас тусдаа

амьдарч байгаа хүүхдийг илрүүлэх, арга хэмжээ зохион байгуулах, нийгмийн хэв журмыг сахих чиглэлээр ажил зохион байгуулах

2. Замын завсар үйлчилгээ, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах тэмдэг, тэмдэглэгээг байршуулах, шинэчлэх, хот хооронд, сум хоорондын замд аюулгүй зорчих нөхцөлийг бүрдүүлэх, бага насны хүүхдийг зориулалтын суудлыг заавал хэрэглэж хэвшүүлэхэд зөвлөгөө өгөх, хяналт тавих

3. Эрх нь зөрчигдсөн, гэмт хэрэг, зөрчлийн хохирогч, холбогдогч хүүхдийн мэдээллийг тухай бүр хүүхдийн төлөө зөвлөлийн дарга / аймгийн Засаг дарга/, түүний Тамгын газар болон холбогдох байгууллагад мэдэгдэн, хүүхэд хамгааллын үйлчилгээнд хамруулж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь хүүхдийн эрхийг хангах

4. Мөрдөн байцаагч, хэсгийн төлөөлөгч, хэв журмын албаны ажилтнуудад гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг хүчирхийллийн үед авах арга хэмжээ, ажиллах аргачлалыг тогтмол өгч, тогтмол сурган чадавхжуулах

Эрүүл мэндийн газарт:

1. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх явцдаа хохирогчийг илрүүлэх, холбогдох байгууллагад заавал мэдээлэх хохирогчийн бэртэл гэмтэл, өвчлөлийн шалтгааныг тэмдэглэж, баримтжуулж, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан үүргийн хэрэгжилтийг хангаж ажиллах

2. Нийт эмнэлгийн ажилтнуудыг хүүхэд хамгааллын эерэг хандлагатай, хүүхэд хамгааллын мэдлэг ойлголттой болгох сургалтад тогтмол хамруулах

3. “Өсвөрийн кабинет”-ыг ажиллуулж, түүгээр дамжуулан өсвөр насны охид, хөвгүүдийн эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх

Мэргэжлийн хяналтын газарт:

1. Цэцэрлэг, сургууль, хүүхдийн байгууллагын байрнаас 100 метрт зайд архи, тамхи, согтууруулах ундаа худалдахгүй, үйлчлэхгүй байх талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, шаардлагатай тохиолдолд тусгай зөвшөөрлийг цуцлах, хаах арга хэмжээ авах

2. Хүүхдийн эрх, хамгаалал аюулгүй байдлыг хангах асуудлаар салбар дундын үзлэг шалгалтыг аймгийн хэмжээнд зохион байгуулах

3. Баар, зочид буудал, цахим тоглоомын газруудын үйл ажиллагаанд холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран улирал тутам хяналт шалгалтыг хийж энэ төрлийн үйлчилгээ эрхлэгчдийн дунд хүүхэд хамгааллын талаарх зөв ойлголт, хандлагыг төлөвшүүлэх чиглэлээр арга хэмжээ тогтмол зохион байгуулах

Иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус байгууллагад:

1. Байгууллага, аж ахуйн нэгжээс гарч буй бүтээгдэхүүн, үйл ажиллагаа нь хүүхдэд эрсдэл учруулахгүй, хүүхдийн эрх ашгийг нэгдүгээрт гэсэн зарчмыг хангахад чиглэх

2. Хувийн хэвшлийн байгууллагууд хүүхдийн эрх, хамгаалал, хүүхдийн хөгжлийн онцлог, хүмүүжлийн эерэг арга, гэр бүлийн боловсрол олгох сургалтыг тогтмол зохион байгуулж байгууллага бүр “Эцэг эхийн зөвлөл” байгуулж үйл ажиллагааг эрчимжүүлж “Хүүхэд хамгааллын бодлого”-ыг хэрэгжүүлэн ажиллах

3. Байгууллагын эцэг эхийн зөвлөлөөр дамжуулан эцэг эхийн үүрэг хариуцлагаа ухамсарлаж хүүхдээ аливаа болзошгүй аюул, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, гэр бүлээ хамгаалах талаар мэдээллээр хангах


Хэвлэл мэдээллийн байгууллагуудад:

1. Хүүхэдтэй холбоотой мэдээллийг сурвалжлах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацахдаа хүүхдийн эрх ашгийг хөндөхгүй, хүүхдийн нууцлалыг хангах, хүүхдэд учрах эрсдэлээс сэргийлж, хүүхдэд ээлтэй сэтгүүл зүйн зарчмыг баримталж ажиллах

2. Иргэдийг соён гэгээрүүлэх зорилгоор нийгмийн хариуцлагын хүрээнд гэр бүл, хүүхэд рүү чиглэсэн эерэг контент нэвтрүүлэг, мэдээ мэдээлэл бэлтгэн цахим орчинд түгээх

2. Албан даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (Д.Өнөрцэцэг), зохион байгуулсан ажил, арга хэмжээ, гарсан үр дүнг аймгийн хэмжээнд нэгтгэн, 2022 оны 05 дугаар сарын 30, 11 дүгээр сарын 30-нд аймгийн Засаг даргад тайлагнахыг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар (Б.Энх-Эрдэнэ)-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ